

Э-Сонин

41 дахь дугаар

Мэдээний Тойм



ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД МОНГОЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙГ СОНИРХОЖ ЭХЭЛЛЭЭ

СЗХ, МХБ-ИЙН ДҮРЭМ, ЖУРАМ ТАНИЛЦУУЛАХ СУРГАЛТ БОЛЛО



ХУВЬЦАА ХУВААСНААР ХУВЬЦААНЫ ХӨРВӨХ ЧАДВАР НЭМЭГДЭНЭ

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН ОНООСОН НЭРИЙГ ӨӨРЧИЛЛӨӨ



MIT-CSD СИСТЕМ АЖЛЫН БУС ӨДРҮҮДЭД АЖИЛЛАХ БОЛОМЖТОЙ БОЛЛО

ЭРЧИМ БОНДЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА



ҮНДЭСНИЙ КОМПАНИУД МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖЭЭС САНХҮҮЖИЛТ ТАТНА

ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

- Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхэлдэг Хонконгийн “Ptarmigan and Eden asset management”, “Firebird Mongolia Fund” болон БиДиСек үнэт цаасны компанийн төлөөлөл Монголын хөрөнгийн биржид зочилж, Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг нээлээ.
- Монголын хөрөнгийн биржийн Хяналт, шалгалтын албанаас СЗХ болон МХБ-ийн Гишүүнчлэл болон Хяналтын журмын өөрчлөлтийн талаарх танилцуулах сургалтыг амжилттай зохион байгуулав.
- СЗХ-ны тогтоолыг үндэслэн Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирлын 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 187 тоот тушаалаар дараах хувьцаат компаниудын оноосон нэрийг өөрчиллөө.
- Mit csd систем амралтын өдрүүдэд ажиллах боломжтой болсон.
- Компаниудыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан санхүүжүүлэх, IPO гаргахад нь дэмжлэг үзүүлэх, гадаад дотоодын хөрөнгө оруулагчидтай холбох бөгөөд орон нутагт үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлд гаргана.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 5-р сарын арилжааны мэдээ



ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД МОНГОЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙГ СОНИРХОЖ ЭХЭЛЛЭЭ

Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхэлдэг Хонконгийн “Ptarmigan and Eden asset management”, “Firebird Mongolia Fund” болон БиДиСек үнэт цаасны компанийн төлөөлөл Монголын хөрөнгийн биржид зочилж, Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн 5225 дахь арилжааг нээж, цан цохилоо.

Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал М.Болор хөрөнгийн биржийн бодлого, үйл ажиллагаа, Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдлын талаар мэдээлэл өгч, Гадаадын хөрөнгө оруулагчид Монголын зах зээлийг сонирхож буйгаа илэрхийлж, зах зээлийн цаашдын чиг хандлагын талаар харилцан санал солилцлоо.

Дашрамд дурдахад Монголын хөрөнгийн бирж Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтран 2016 оны 4 сарын 26-27-нд Лондон хотноо “Монгол–Лондонгийн бизнес форум”-ыг зохион байгуулж гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, Монголын хөрөнгийн зах зээл, Монголын компаниудыг сурталчлах ажлыг зохион байгуулсан билээ.



СЗХ, МХБ-ИЙН ДҮРЭМ, ЖУРАМ ТАНИЛЦУУЛАХ СУРГАЛТ БОЛЛОО

2016 оны 5 дугаар сар 19-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн Хяналт, шалгалтын албанаас СЗХ болон МХБ-ийн Гишүүнчлэл болон Хяналтын журмын өөрчлөлтийн талаарх танилцуулах сургалтыг амжилттай зохион байгууллаа. Уг сургалтад МХБ-ийн Гүйцэтгэх захирал М.Болор, СЗХ-ны Үнэт цаасны хяналтын хэлтсийн дарга Б.Долгорсүрэн, Арилжаа эрхлэгчдийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Хуяг нар илтгэл тавьсан бөгөөд нийт 29 Гишүүн Үнэт Цаасны Компанийн 32 төлөөлөл уг сургалтад хамрагдав.

Уг танилцуулах сургалтын хүрээнд нь Гишүүн үнэт цаасны компанийн үйл ажиллагаандаа мөрдөж буй дүрэм журам, үүргийн хэрэгжилт болон авах арга хэмжээ тэдгээрийн ёс зүйн дүрэм, Гишүүн ҮЦК-иудын арилжааг нэмэгдүүлэх, МХБ-ийн Гишүүн үнэт цаасны компаниудын хяналт шалгалтын үйл ажиллагааны болон үнэт цаасны зах зээлд санхүүгийн шинэ үйлчилгээ нэвтрүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөн санал бодлоо харилцан солилцлоо.

Ингэснээр үнэт цаасны компанийн үйл ажиллагаа сайжирч, үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадвар нэмэгдэх ач холбогдолтой юм.



ХУВЬЦАА ХУВААСНААР ХУВЬЦААНЫ ХӨРВӨХ ЧАДВАР НЭМЭГДЭНЭ

2016 онд АПУ, СҮҮ, УБ-БҮК зэрэг компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас хувьцааг хуваах шийдвэрийг гаргасан.

Хувьцаат компанийн нэгж хувьцааны ханш өндөр байгаагаас зарим компани өөрийн хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хувьцааг хуваадаг байна.

2008 онд “АПУ” ХК нэгж хувьцааны зах зээлийн ханш 54,000 төгрөгт хүрч хөрвөх чадвар муудсан тул компанийн зүгээс хувьцааг 1:100 хувааж нэгж хувьцааны үнийг 540 төгрөг болгосон нь тухайн компанийн хувьцааны эрэлтийг өсгөж, хөрвөх чадварыг нэмэгдүүлж дараагийн 3 сард хувьцааны ханш 70 гаруй хувиар өссөн бөгөөд өнөөдрийн байдлаар тус компанийн нэгж хувьцааны хаалтын ханш 3700 төгрөг байна. Мөн “Таван толгой” ХК-ийн нэгж хувьцааны ханш 730,000 төгрөгийн үнэтэй үнэтэй болж хөрвөх чадвар муудсан тул хувьцааг 1:100 болгож хувааснаар нэгж хувьцааны үнэ 7300 төгрөг болгосон бөгөөд хувьцааны эргэлт нэмэгдэж, нэг жилийн дотор хувьцааны ханш 42.8 хувиар өсч, зах зээлийн үнэлгээ 500 тэрбум төгрөг болж, МХБ-ийн хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй компани болж байсан.

2016 онд АПУ, СҮҮ, УБ-БҮК зэрэг компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас хувьцааг хуваах шийдвэрийг гаргасан юм.

Хувьцаа хувааснаараа компани болон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд дараах ач холбогдолтой. Үүнд:

- Хувьцааны хөрвөх чадвар сайжрах /Нэгж хувьцааны ханш багассанаар авч зах зээл дээр эрэлт нэмэгдэнэ/
- Компанийн зах зээлийн үнэлгээ бодитоор тогтоогдож, хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй хувьцааны үнэ цэнэ өсөх
- Хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдсэнээр компанийн засаглал сайжрах

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН ОНООСОН НЭРИЙГ ӨӨРЧИЛЛӨӨ

Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолыг үндэслэн Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирлын 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 187 тоот тушаалаар дараах хувьцаат компаниудыг оноосон нэрийг өөрчиллөө. Үүнд:

1. "Шимтлэг" ХК-ийн оноосон нэрийг **"Хар хорум пропертийс"** ХК, Үнэт цаасны код:**AMT /175/**
2. "ХААБЗ" ХК-ийн оноосон нэрийг **"Хүннү менежмент"** ХК, Үнэт цаасны код:**HBZ /65/**
3. "Жавсхлант хараа" ХК-ийн оноосон нэрийг **"Е-Моние"** ХК, Үнэт цаасны код:**HCH /408/**
4. "Арилжаа-Импекс" ХК-ийн оноосон нэрийг **"Стандарт ноос"** ХК, Үнэт цаасны код:**ALI /420/**

MIT-CSD СИСТЕМ АЖЛЫН БУС ӨДРҮҮДЭД АЖИЛЛАХ БОЛОМЖТОЙ БОЛОО

Иргэд болон гишүүн үнэт цаасны компаниудын зүгээс амралтын өдрүүдэд тус системийг ажиллуулах хүсэлт манай компанид ирүүлсэн болно. Энэхүү хүсэлтийг үндэслэн манай компани шуурхай ажиллаж, системийн аюулгүй болон тасралтгүй ажиллах боломжийг хангаж чадсанаар амралтын өдрүүдэд ажиллах боломжтой болсон.

Сүүлийн үед иргэдийн үнэт цаасны данс нээлгэх хүсэлт нэмэгдсэнтэй холбогдуулан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн үнэт цаасны компаниуд ачаалал ихтэй ажиллах болсон ба үнэт цаасны данс нээхэд ашиглагддаг дэд бүтэц болох систем /MIT-CSD/ нь зөвхөн ажлын өдрүүдэд ажилладаг. Иргэд болон гишүүн үнэт цаасны компаниудын зүгээс амралтын өдрүүдэд тус системийг ажиллуулах хүсэлт манай компанид ирүүлсэн болно. Энэхүү хүсэлтийг үндэслэн манай компани шуурхай ажиллаж, системийн аюулгүй болон тасралтгүй ажиллах боломжийг хангаж чадсанаар амралтын өдрүүдэд ажиллах боломжтой боллоо.

Амралтын өдрүүдэд үүсгэсэн үнэт цаасны данс дараа долоо хоногийн Мягмар гарагт идэвхжих бөгөөд, тус өдрөөс эхлэн арилжаанд оролцох боломжтой болох юм. Дэд бүтэц болон системтэй холбоотой асуудлыг **310520 /4111, 4114, 4115/** дугаарын утсаар тодруулна уу.

ЭРЧИМ БОНДЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА

“Эрчим бонд”-ын хугацаа дуусч, үндсэн болон хүүгийн эргэн төлөлт бүрэн төлөгдсөн тул бондыг Хорооны бүртгэлээс хасах шийдвэр гаргалаа.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны ээлжит 9 дүгээр хуралдаанаар “Эрчим инженеринг” ХХК-иас гаргасан “Эрчим бонд”-ын хугацаа дуусч, үндсэн болон хүүгийн эргэн төлөлт бүрэн төлөгдсөн тул бондыг Хорооны бүртгэлээс хасах шийдвэр гаргалаа. Эрчим бонд нь 6 сарын хугацаатай, жилийн 18.5 хувийн хүүтэй, үндсэн болон хүүгийн төлбөр хугацааны эцэст нэг удаа төлөгдөхөөр нөхцөлтэй гарч, анхдагч зах зээл дээр амжилттай арилжаалагдсан юм. “Эрчим инженеринг” ХХК нь нийтэд санал болгон өрийн хэрэгсэл гаргах замаар 453,750,000 төгрөг татан төвлөрүүлсэн байна.

Даатгагдсан компанийн бонд нь санхүүгийн даатгалын шинэ төрлийн бүтээгдэхүүн төдийгүй хүүгийн болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг даатгалын компани 100 хувь хариуцан батлан дааж буй учир эрсдэлгүй бүтээгдэхүүнд тооцогдох юм.

Санхүүгийн Зохицуулах Хорооны зүгээс хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэхэд онцгой анхаарч байгаа бөгөөд аж ахуйн нэгжүүд бонд гаргах замаар хөрөнгийн зах зээл дээрээс санхүүжилт татах боломжтой тухай мэдээлэв.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

ҮНДЭСНИЙ КОМПАНИУД МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖЭЭС САНХҮҮЖИЛТ ТАТНА

Монголын хөрөнгийн бирж Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, МҮХАҮТ-ын ерөнхийлөгч Б.Лхагважав Монголын хөрөнгийн биржийн 5238 дахь арилжааг нээж, цан цохилоо.

Санамж бичигт Үндэсний томоохон төслүүдийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан санхүүжүүлэх, IPO гаргахад нь дэмжлэг үзүүлэх, гадаад дотоодын хөрөнгө оруулагчидтай холбох бөгөөд орон нутагт үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлд гарахад дэмжлэг үзүүлэх талаар тусгав.

2015 онд Монголын хөрөнгийн зах зээл дээрээс үндэсний үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүд нийт 100 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татсан бөгөөд энэ онд Төрийн өмчит аж ахуйн нэгж болон дотоодын компаниуд IPO, нэмэлт хувьцаа гаргаж хөрөнгө босгохоор ажиллаж байна.





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

MONGOLIAN STOCK EXCHANGE

Вeб: www.mse.mn Утас:(976)-11-310456 Факс: (976)-11-325170 Email: trading_mn@mse.mn Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатарын талбай-2

САРЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

2016 оны 05 дугаар сар

Арилжааны товч мэдээ

Арилжигдсан ширхэг	483 178
Нийт үнийн дүн /төг/	1 890 682 505
Хэлцлийн тоо	1 199
Арилжигдсан үнэт цаасны тоо	66
Зах зээлийн үнэлгээ /төг/	1 319 247 550 196


ТОП-20 индекс

Хаалт	11 042,48
Өөрчлөлт /%/	1,85

MSE ALL индекс

Хаалт	782,11
Өөрчлөлт /%/	1,66

ТОП 20 ИНДЕКС



Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхэгээр:				Үнийн дүнгээр:			
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	№	Симбол	Үнэт цаасны нэр	Үнийн дүн
1	MNP	МОНГОЛ ШУУДАН	173 985	1	APU	АПУ	239 214 514
2	APU	АПУ	63 443	2	DES	ДОРНОД ХУДАЛДАА	147 200 000
3	RMC	РЕМИКОН	38 461	3	MNP	МОНГОЛ ШУУДАН	49 878 592
4	HGN	ХӨХ ГАН	29 652	4	SUU	СҮҮ	43 725 100
5	TTL	ТАВАН ТОЛГОЙ	24 827	5	TTL	ТАВАН ТОЛГОЙ	35 417 305

Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	BAN	БАГАНУУР	2 600,00		73,33
2	SHG	ШАРЫН ГОЛ	3 500,00		62,41
3	NXE	НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ	1 710,00		49,34
4	MNH	МОНГОЛ НЭХМЭЛ	5 740,00		43,46
5	MIE	МАТЕРИАЛИМПЕКС	10 120,00		34,93

Хамгийн их бууралттай үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	BUC	УБ БҮК	26 100,00		-25,43
2	GTJ	ГУРИЛ ТЭЖЭЭЛ БУЛГАН	1 950,00		-17,02
3	HML	ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИ	425,00		-15,00
4	AOI	АВТОИМПЕКС	2 050,00		-14,94
5	MMX	МАХИМПЕКС	2 255,00		-14,91

Засгийн газрын үнэт цаас: /анхдагч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	Хугацаа /долоо хоног/	Хүүгийн хэмжээ %
1	-	-	-	-	-	-
2	-	-	-	-	-	-
3	-	-	-	-	-	-

Засгийн газрын үнэт цаас: /хоёрдогч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Дээд ханш	Доод ханш	Сүүлчийн ханш
1	ZGEB-BL-14/08/16-A0081-0	2 500	246 850 000	98 740	98 740	98 740
2	ZGEB-BL-15/08/16-A0102-0	1 938	187 404 600	96 700	96 700	96 700
3	ZGEB-BL-15/08/16-A0102-0	1 654	159 941 800	96 700	96 700	96 700
4	ZGEB-BL-15/08/16-A0102-0	520	50 284 000	96 700	96 700	96 700
5	ZGEB-BL-15/08/16-A0102-0	5 200	504 400 000	97 000	97 000	97 000
6	ZGEB-BL-15/08/16-A0102-0	47	4 589 080	97 640	97 640	97 640
7	ZGEB-BL-15/11/16-A0075-0	341	32 060 820	94 020	94 020	94 020
8	ZGEB-BL-15/11/16-A0075-0	53	4 983 060	94 020	94 020	94 020
9	ZGEB-BL-31/08/16-A0108-0	108	10 479 240	97 030	97 030	97 030